



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/73

Шивээговь сум

Сумын баяр наадмын зардалд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/183 дугаар захирамж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2022 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Баяр наадам”-ын шууд худалдан авалтыг хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- | | |
|-----------------------|---|
| Комиссын дарга: | Ц.Цэрэндорж
(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Гишүүн: | Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Л.Цэнд-Аюуш
(Сан хариуцсан нягтлан бодогч)
Б.Алтжин
(Нярав) |
| Нарийн бичгийн дарга: | Ц.Замбага
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг) |

төлөвлөлт, худалдан авах ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн)

2. Сумын баяр наадамд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийн төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Баяр наадамд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4. Үндэсний их баяр наадамд зарцуулагдах төсөвт хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ